



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 4/201

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Овоо сумын Жавхлант багийн иргэн Сайнбаярын Ариунзул нь 2025 оны 11 дугаар сарын 07-08-ний өдрүүдэд Франц улсын Парис хотод зохион байгуулагдсан гранд мастерсын Дэлхийн аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээнд мөнгөн медаль хүртсэн тул хүндэтгэл үзүүлж 1,500,000(нэг сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР